

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛС, АМЕРИКИЙН  
НЭГДСЭН УЛСЫН ХООРОНДЫН КОНСУЛЫН  
К О Н В Е Н Ц

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Америкийн Нэгдсэн Улс хоёр улсын хоорондын найрсаг харилцааг өргөтгөн хөгжүүлэхийг эрмэлзэж, консулын харилцааг зохицуулан иргэдийнхээ эрх, ашиг сонирхлыг хамгаалах явдлыг хөггөвчлөхийг хүсч,

Энэхүү конвенцид нарийвчлан тусгагдаагүй асуудлуудыг консулын харилцааны тухай 1963 оны 4 дүгээр сарын 24-ний Венийн Конвенцийн дагуу зохицуулахаа нотлон,

Консулын конвенц байгуулахаар шийдвэрлэн дор дурдсан зүйлсийг хэлэлцэн тохиров.

ЦАХИМ АШМУДАТ ЭРХИМ ХУВЬ

ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ

I ХЭСЭГ  
ТОДОРХОЙЛОЛТ  
I ЛҮГЭЭР ЗҮЙЛ  
ТОДОРХОЙЛОЛТ

I. Энэ Конвенцид гарах дор дурдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно:

- а/ "консулын газар" гэж ерөнхий консулын газар, консулын газар, дэд консулын газар, консулын төлөөлөгчийн газрыг тус тус хэлнэ,
- б/ "консулын тойрог" гэж консулын газар консулын үүрэг гүйцэтгэхэд зориулан тогтоосон районыг хэлнэ,
- в/ "консулын газрын тэргүүн" гэж консулын газрыг удирдахаар томилогч улсаас томилогдсон ерөнхий консул, консул, дэд консул, консулын төлөөлөгчийг хэлнэ,
- г/ "консулын албан тушаалтан" гэж консулын газрын тэргүүнийг оролцуулан консулын үүрэг гүйцэтгэхээр томилогч улсаас томилогдсон хүнийг хэлнэ,
- д/ "консулын ажилтан" гэж консулын газарт захиргаа, техникийн үүрэг гүйцэтгэж байгаа хүнийг хэлнэ,
- е/ "үйлчилгээний бүрэлдэхүүний гишүүн" гэж консулын газрын дотоод үйлчилгээнд ажиллаж байгаа хүнийг хэлнэ,
- ё/ "консулын газрын гишүүн" гэж консулын албан тушаалтан, консулын ажилтан буюу үйлчилгээний бүрэлдэхүүний гишүүнийг хэлнэ,
- ж/ "гэр бүлийн гишүүд" гэж консулын газрын гишүүний нөхөр буюу эхнэр, насанд хүрээгүй хүүхэд болон хамт оршин суугаа гэр бүлийн бусад гишүүнийг хэлнэ,

- з/ "консулын газрын байр" гэж хэн эмчлэх эрхтэйг үл харгалзан гагцхүү консулын газрын зорилгод ашиглаж байгаа барилга, барилгын хэсэг, тэдгээрт хамарах газрыг хэлнэ,
- и/ "консулын архив" гэж консулын газрын бүх бичиг баримт, захидал, ном, кино, авиа бичлэгийн хальс, бүртгэл, шифр, код, картны сан болон тэдгээрийг халгалж хамгаалахад зориулсан тавилга төхөөрөмжийг хэлнэ,
- к/ "томилогч улсын хөлөг онгоц" гэж цэргийн хөлөг онгоцноос бусад томилогч улсын далсааг манцуулсан бөгөөд түүний бүртгэлтэй хөлөг онгоцыг хэлнэ,
- л/ "томилогч улсын агаарын хөлөг" гэж цэргийн агаарын хөлгөөс бусад томилогч улсын хуулийн дагуу томилогч улсын таних тэмдэг, бүртгэлтэй агаарын хөлгийг хэлнэ,
- м/ "хууль" гэж улс, орон нутгийн бүх хууль дүрэм, мөн шүүх, хууль тогтоох, хуулийн болон захиргааны бусад байгууллагын хуулийн хүчинтэй шийдвэрийг хэлнэ.

2. Энэ Конвенцийн томилогч улсын иргэдэд хамаарах заалтууд нь утгаараа тохирвол томилогч улсын хуулийн этгээдэд мөн хамарна.

II ХЭСЭГ

КОНСУЛЫН ГАЗРЫГ БАЙГУУЛАХ, КОНСУЛЫН ГАЗРЫН  
ГҮЙШҮҮДИЙГ ТОМИЛОХ

2 ДУГААР ЗҮЙЛ

КОНСУЛЫН ГАЗРЫГ БАЙГУУЛАХ

1. Консулын газрыг хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт гагцхүү тэр улсын зөвшөөрлөөр байгуулж болно.

2. Консулын газрын байрлах газар, зэрэг, консулын тойрог, тэдгээрийн цаашдын өөрчлөлтийг томилогч улс, хүлээн авагч улс тохиролцож тогтооно.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ХУВИЛ

ГАДААД ХАРИЛЦАДНЫ ТӨВ АРХИВ

### 3 ДУГААР ЗҮЙЛ

#### КОНСУЛЫН ГАЗРЫН ТЭРГҮҮНИЙГ ТОМИЛОХ

1. Томилгогч улс консулын газрын тэргүүнийг томилсон тухай патент буюу мэдэгдлийг бичгээр дипломат шугамаар хүлээн авагч улсад илгээнэ. Уг патент буюу мэдэгдэлд консулын газрын тэргүүний овог нэр, иргэний харьяалал, хүйс, зэрэг, товч намтар, үүргээ гүйцэтгэж эхлэх өдөр, консулын газрын зэрэг, байрлах газар, консулын тойргийг заана.

2. Хүлээн авагч улс патент буюу мэдэгдлийг хүлээн авмагц консулын газрын тэргүүнийг томилсныг татгалзахгүй бол түүнд экзекватур буюу эрхийн еер бичиг баримтыг аль болох богино хугацаанд үнэгүй олгоно. Хэрэв хүлээн авагч улс уг хүнийг томилсныг татгалзах байгаа бол шалтгаанаа тайлбарлах үүрэггүй.

3. Хүлээн авагч улс экзекватур буюу эрхийн еер бичиг баримт олгохын өмнө үүргээ түр гүйцэтгэж эхлэхийг консулын газрын тэргүүнд зөвшөөрч болно.

4. Консулын газрын тэргүүн үүргээ түр ч боловч гүйцэтгэж эхэлмагц хүлээн авагч улс энэ тухай консулын тойргийн эрх бүхий байгууллагад даруй мэдэгдэж, консулын газрын тэргүүн үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах бүх арга хэмжээг авах үүрэгтэй.

ЦАХИМ ГИШИГТЭЙ  
ГЭРЛЭГ ХАРАМГАЛТАНД  
ӨВ АРХИВ

#### 4 ДҮГЭЭР ЗҮЙЛ

##### КОНСУЛЫН ГАЗРЫН БУСАД ГИШҮҮНИЙГ ТОМИЛОХ

1. Томилогч улс консулын газарт томилогдсон консулын албан тушаалтны хүрэлцэн ирэх өдөр, овог нэр, иргэний харьяалал, зэрэг, албан тушаалыг хүлээн авагч улсад урьдчилан бичгээр мэдэгдэнэ.

2. Томилогч улс мөн дараах зүйлийг 30 хоногийн дотор хүлээн авагч улсад бичгээр мэдэгдэнэ.

а/ консулын ажилтны томилогдсон, хүрэлцэн ирсэн өдөр, овог нэр, иргэний харьяалал,

б/ консулын газрын гишүүд бүрмөсөн буцсан, үүргээ дуусгасан тухай болон консулын газарт ажиллах үед нь гарсан бөгөөд эрхийн байдалд нь нөлөөлсөн бусад өөрчлөлтийн тухай,

в/ консулын газрын гишүүний гэр бүлийн гишүүн хүрэлцэн ирсэн, бүрмөсөн буцсан, хэн нэг хүн гэр бүлийн гишүүн болсон, эсвэл гэр бүлийн гишүүн байхаа больсон тухай,

г/ хүлээн авагч улсын иргэн буюу байнга оршин суугчийг консулын газрын гишүүнээр ажиллуулсан, ажлаас халсан тухай.

3. Хүлээн авагч улс консулын газрын гишүүд болон тэдний гэр бүлийн гишүүдэд зохих бичиг баримт олгоно. Энэ заалт хүлээн авагч улсын иргэн буюу байнга оршин суугчид хамаарахгүй.

5 ДУГААР ЗҮЙЛ

КОНСУЛЫН ГАЗРЫН ГИШҮҮДИЙН ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛ

1. Консулын албан тушаалтан нь хүлээн авагч улсын иргэн биш буюу байнга оршин суугч биш, харин томилогч улсын иргэн байна.
2. Консулын ажилтан нь томилогч улсын иргэн, хүлээн авагч улсын иргэн, эсвэл гуравдахь улсын иргэн байж болно.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ХЭВЭР

ГЭРЛЭЭД ХАРИЛЦАДНЫ ТӨВ АРХИВ

6 ДУГААР ЗҮЙЛ

КОНСУЛЫН ГАЗРЫН ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ ДУУСАХ

1. Хүлээн авагч улс консулын албан тушаалтныг, эсвэл консулын ажилтанг тааламжгүй этгээд гэж томилогч улсад шалтгаанаа тайлбарлахгүйгээр дипломат шугамаар хэдийд ч мэдэгдэж болно. Энэ тохиолдолд томилогч улс уг хүнийг татан дуудах буюу үүргийг нь дуусгах үүрэгтэй.

2. Хэрэв томилогч улс энэ зүйлийн I-д заасан үүргээ зохах хугацаанд биелүүлэхгүй бол хүлээн авагч улс уг хүнийг консулын газрын гишүүн гэж хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж болно.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ХҮБЭ

ГАДААД ХАРИЛЦАДНЫ ТӨВ АРХИВ

## 7 ДУГААР ЗҮЙЛ

### КОНСУЛЫН ГАЗРЫН ТЭРГҮҮНИЙ ҮҮРГИЙГ ТҮР ГҮЙЦЭТГЭХ

1. Консулын газрын тэргүүн ямар нэг мөлтганаар үүргээ гүйцэтгэж чадахгүй болох, түр эзгүй буюу орон тоо нь сул байх үед томилогч улсаас хүлээн авагч улсад суугаа тухайн болон өөр консулын газрын консулын албан тушаалтан буюу дипломат төлөөлөгчийн газрын дипломат бүрэлдэхүүний гишүүн консулын газрын тэргүүний үүргийг түр гүйцэтгэхээр томилогч улсаас томилогдож болно. Уг хүний овог нэрийг хүлээн авагч улсын Гадаад явдлын Яаманд буюу Төрийн департаментад бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

2. Консулын газрын тэргүүний үүргийг түр гүйцэтгэх хүн консулын газрын тэргүүний бүх үүргийг гүйцэтгэх, энэ Конвенцийн дагуу консулын газрын тэргүүнд олгосон эрх ямба, дархан эрхийг эдлэх эрхтэй.

3. Консулын газрын тэргүүний үүргийг түр гүйцэтгэх дипломат төлөөлөгчийн газрын дипломат бүрэлдэхүүний гишүүн энэ Конвенцийн 35 дугаар зүйлийн 3-т зааснаас бусад тохиолдолд дипломатня хувьд түүнд олгосон эрх ямба, дархан эрхийг хэвээр эдэлнэ.

ЦАХИМ АШИГЛАГАХ

ГАДААД ХАРИУЦЛАГААНЫ ТӨВ АРХИВ

8 ДУГААР ЗҮЙЛ

КОНСУЛЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, КОНСУЛЫН АЛБАН  
ТУШААЛТНЫГ ХАМГААЛАХ

1. Хүлээн авагч улс консулын газраас үйл ажиллагаагаа хэвийн явуулах, үүргээ гүйцэтгэх зохих нөхцөлийг хангахын тулд шаардлагатай бүх арга хэмжээг авна.

2. Хүлээн авагч улс консулын албан тушаалтанд хүндэтгэл үзүүлж түүний бие, эрх чөлөө, нэр төрд халдахаас сэргийлэх, консулын албан тушаалтан үүргээ гүйцэтгэх, энэ Конвенцид заасан эрх ямба, дархан эрх эдлэхэд нь холбогдох бүх арга хэмжээг авна.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ХЭР  
ГАДААД ХАРИЛЦАДАНЫ ТӨВ АРХИВ

9 ДҮГЭЭР ЗҮЙЛ

КОНСУЛЫН ГАЗРЫН БАЙР, ОРОН СУУЦ ОЛЖ АВАХ

1. Консулын газрын байр, консулын газрын гишүүдийн орон сууц олж авах буюу барих, ашиглахад хүлээн авагч улс харилцан адил байх, тохиролцсон үнэ хөлсөөр олгох зарчмыг баримталж туслацгаа үзүүлнэ. Консулын газрын байр, консулын газрын гишүүдийн орон сууцтай холбогдсон аливаа асуудлыг томилгогч улс, хүлээн авагч улс тохиролцож шийдвэрлэнэ.

2. Томилгогч улс консулын газрын байр, консулын газрын гишүүдийн орон сууц олж авах буюу барих, ашиглахдаа барилга барих, хотын төлөвлөлтийн болон газар эдэлбэрийн тухай хүлээн авагч улсын холбогдох хуулийг мөрдөнө.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ҮНЭ  
ГАДААД ХАРИУЛЦАДАНЫ ТӨВ АРХИВ

III ХЭСЭГ

ЭРХ ЯМБА, ДАРХАН ЭРХ

10 ДУГААР ЗҮЙЛ

ТӨРИЙН СҮҮД, ДАЛБААГ ХЭРЭГЛЭХ

1. Томилогч улсын төрийн сүлд, томилогч улс болон хүлээн авагч улсын хэлээр бичсэн консулын газрын хаягийг консулын газрын байранд, түүний хаалганд буюу хаалганы хахууд байрлуулж болно.

2. Томилогч улсын төрийн далбаа болон консулын далбааг консулын газар, консулын газрын тэргүүний өргөө, албан үүргээ гүйцэтгэж яваа үед тээврийн хэрэгсэл дээр нь мандуулж болно.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ХУВЬ

ГАДААДХАРИЛЦАДНЫ ТӨВ АРХИВ

## II ДҮГЭЭР ТҮМ

### КОНСУЛЫН ГАЗРЫН БАЙРЫГ ХАМГААХ ТАВИАЛ

1. Консулын газрын байр хялбартай байна. Хүлээн авагч улсын албаны хүмүүс тухайн консулын газрын тэргүүн буюу томлогч улсын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, эсвэл тэднийг аль нэгний нэр зурсан хүнийг зөвшөөрөлтүүдгээр консулын газрын байранд орж болохгүй. Хэргийн гал гүймэр буюу хамгаалах арга хэмжээ хойшуулалтгүй авах шаардлагатай бусад аюул тохиолдол консулын газрын тэргүүний зөвшөөрөл байгаа гэж үзэх болно.

2. Консулын газрын байр, тавилга төхөрөмж болон бусад эд хөрөнгө, мөн тээврийн хэрэгслийг нэгилж, дайчлах, савтуулах болохгүй бөгөөд гүйцэтгэх арга хэмжээнээс чөлөөлнө. Консулын байр, түүний тавилга төхөрөмж, бусад эд хөрөнгө, тээврийн хэрэгсэл улсыг батлан хамгаалах болон нийгмийн бусад хэрэгцээнийг алдвал дайчлаганаас чөлөөлөгдөх дархан эрхтэй байна. Хэрэв улсыг батлан хамгаалах буюу нийгмийн бусад хэрэгцээний зорилгоор консулын байр, орон байрыг дайчлах шаардлага гарвал хүлээн авагч улс консулын үүргээ гүйцэтгэхэд нь саад болохооргүй боломжийн бүх арга хэмжээг авч томлогч улсад зохиц үр амгтай төлбөрийг даруй тэмнэ.

3. Хүлээн авагч улс консулын газрын байранд хялгах, хохиrol учруулахаас хамгаалах, консулын газрын тавиан байрлыг асчагдуулах, нэр төрийг гутаахаас сэргийлэх бүх арга хэмжээ авах үүрэгтэй.

4. Энэ зүйлийн 1,2,3-ын зэмлэ консулын газрын тэргүүний орон байранд нэгэн ядал хамарна.

ГАДИМУД ХАФИМУЛЛАДАН ДИГИТӨГӨӨ АРХИВ

12 ДУГААР ЗҮЙЛ

КОНСУЛЫН АРХИВЫН ХАЛДАШГҮЙ БАЙДАЛ

Консулын архив хаана ч, хэдийд ч халдашгүй байна.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ХУВЬ

ГАДААД ХАРИЛЦАДНЫ ТӨВ АРХИВ

## 13 ДУГААР ЗҮЙЛ ЧӨЛӨӨТЭЙ ХАРИЛЦАХ

1. Консулын газар томилогч улсын засгийн газар, дипломат төлөөлөгчийн газар, бусад консулын газартай чөлөөтэй харилцах эрхтэй. Консулын газар энэ зорилгоор холбооны бүх хэрэгсэл, дипломат болон консулын элч, шифр болон кодны мэдээ, дипломат болон консулын шууданг ашиглаж болно. Консулын газар радио нэвтрүүлгийн хэрэгслийг гагцхүү хүлээн авагч улсын зөвшөөрлөөр байрлуулж ашиглана.

2. Томилогч улсын консулын газар холбооны нийтийн хэрэгслийг томилогч улсын дипломат төлөөлөгчийн газрын нэгэн адил нэхдөдөөр ашиглана.

3. Холбооны ямар хэрэгслээр илгээснийг үл харгалзан консулын газрын албан захидал, гадна талдаа албан ёсны шинжийг нь тодорхойлсон таних тэмдэгтэй битүүмжилсэн консулын шуудан болон ачаа халдашгүй байна. Тэдгээрт албан захидал болон гагцхүү албан хэрэгцээнд зориулсан эд юмсаас өөр ад юмс байж болохгүй.

4. Энэ зүйлийн 3-т заасан консулын шуудан, ачаа болон консулын газрын захидлыг задлан үзэж буюу саатуулж болохгүй. Харин хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага эдгээр шуудан болон ачаанд албан захидал, бичиг баримтаас өөр эд юмс буюу албан хэрэгцээнд зориулаагүй эд юмс байна гэж үзэх баттай үндэслэл байвал уг шуудан буюу ачааг өөрсдийн дэргэд нээн үзүүлэхийг томилогч улсын эрх бүхий төлөөлөгчөөс шаардаж болно. Хэрэв томилогч улсын эрх бүхий төлөөлөгч энэ шаардлагыг биелүүлэхээс татгалзвал шуудан буюу ачааг буцаана.

5. Томилогч улсын консулын элч хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт үүргээ гүйцэтгэх үедээ хамгаалалтад байна. Консулын элч

хувийн халдашгүй байдалтай бөгөөд түүнийг ямар нэг хэлбэрээр баривчилж буюу албадан саатуулж болохгүй. Энэ заалт консулын түр элчид мөн хамарах боловч түүний дархан эрх нь итгэмжилсэн консулын шууданг зохих газарт нь хүргэж өгснөөр дуусна.

6. Консулын шууданг томилогч улсын хөлөг онгоцны ахмад буюу агаарын хөлгийн даргад итгэмжлэн өгч болно. Түүнд шуудангийн тоог заасан албан бичиг баримт олгох бөгөөд түүнийг элч гэж үзэхгүй. Томилогч улс хүлээн авагч улсын холбогдох байгууллагатай тохиролцсоны дагуу хүлээн авагч улсын аюулгүй байдлын хуулийг баримтлан консулын албан тусгаалтан консулын шууданг хөлөг онгоцны ахмад болон агаарын хөлгийн даргаас шууд, саалгүй гардан өгч буюу мөн тийнхүү хүлээлгэн өгч болно.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ҮНЭ  
УДИМД ХАРИЛЦАДНЫ ТӨВ АРХИВ

14 ДҮГЭЭР ЗҮЙЛ

КОНСУЛЫН АЛБАН ТУШААЛТНЫ ХУВИЙН ХАЛДАНГУЙ  
БАЙДАЛ

1. Хүнд гэмт хэрэг үйлдсэний улмаас шүүхийн эрх бүхий байгууллагын тогтоол гарснаас бусад тохиолдолд консулын албан тушаалтныг баривчилж буюу урьдчилан албадан саатуулж болохгүй.

2. Энэ зүйлийн I-д зааснаас бусад тохиолдолд зөвхөн шүүхийн хүчин төгөлдөр тогтоолыг биелүүлж байгаа биш бол консулын албан тушаалтныг гянданд хорьж буюу хувийн эрх чөлөөг нь ямар нэг хэлбэрээр хязгаарлаж болохгүй.

3. Консулын албан тушаалтан түүний эсрэг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа эхэлбэл эрх бүхий байгууллагад хүрэлцэн очих үүрэгтэй. Гэхдээ байцаан шийтгэх ажиллагааны үед түүнийг албан байдлыг нь харгалзан хүндэтгэж, консулын үүргээ гүйцэтгэхэд нь энэ зүйлийн I-д зааснаас бусад тохиолдолд саад учруулахаас аль болох зайлсхийх үүрэгтэй. Консулын албан тушаалтныг энэ зүйлийн I-д заасны дагуу албадан саатуулах шаардлага гарвал байцаан шийтгэх ажиллагааг аль болох богино хугацаанд эхлэх үүрэгтэй.

ЦАХИМ АЛБАН ТУШААЛТНЫ ХУВИЙН ХАЛДАНГУЙ

ГАДААД ХАРИУТГАХ АЖЛААНЫ ТӨВ АРХИВ

15 ДУГААР ЗҮЙЛ

ХҮЛЭЭН АВАГЧ УЛСЫН ХУУЛИЙН ХАРИУЛАГААС  
ЧӨЛӨӨЛӨГДӨХ ДАРХАН ЭРХ

1. Консулын газрын гишүүд консулын үүрэг гүйцэтгэх үедээ үйлдсэн хэргийн хувьд хүлээн авагч улсын шүүх, захиргааны байгууллагын өмнө хүлээх хариуцлагаас чөлөөлөгдөнө.

2. Энэ зүйлийн 1-ийн заалт иргэний дор дурдсан нэхэмжлэлд хамаарахгүй:

- а/ консулын газрын гишүүнээс томилогч улсын төлөөлөгчийн хувьд шууд буюу шууд бусаар үүрэг хүлээлгүүгээр байгуулсан хэлцэлтэй холбогдсон нэхэмжлэл,
- б/ хүлээн авагч улсад тээврийн хэрэгслийн ослоос болж учирсан хохиролтой холбогдуулан гуравдахь этгээдээс гаргасан нэхэмжлэл.

ЦАХИМ АШИГЛАГЧИЙН ХЭВЧ

ГАДИЛД ХАРИУЦАДНЫ ТӨВ АРХИВ

16 ДУГААР ЗҮЙЛ

ГЭРЧИЙН МЭДҮҮЛЭГ ӨГӨХӨӨС ЧӨЛӨӨЛӨГДӨХ  
ДАРХАН ЭРХ

1. Консулын газрын гишүүд шүүхийн болон захиргааны журмаар хэрэг шийдвэрлэхэд гэрчийн мэдүүлэг өгөхөөр дуудагдаж болно. Хэрэв консулын албан тушаалтан мэдүүлэг өгөхөөс татгалзвал түүнд албадлага, шийтгэлийн арга хэмжээ хэрэглэж болохгүй. Энэ зүйлийн 2-т зааснаас бусад тохиолдолд консулын ажилтан мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхгүй.

2. Консулын газрын гишүүд албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон асуудлаар мэдүүлэг өгөх болон албан бичиг баримт, захиалгыг өгөхөөс татгалзах эрхтэй. Тэд мөн мэргэжилтний хувьд томилогч улсын хууль, түүнийг хэрэглэх, тайлбарлах талаар мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй.

3. Хүлээн авагч улсын байгууллага консулын газрын гишүүнээс мэдүүлэг авахдаа албан үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулахаас зайлсхийх бүх арга хэмжээг авна. Боломжтой бол мэдүүлгийг бичгээр, эсвэл консулын газрын байранд, эсвэл консулын газрын гишүүний орон сууцанд амаар авч болно.

ЦАХИМ АЖИЛЛАГА

ГАДААД ХАРИУЦАГЧИНЫ ТӨВ АРХИВ

## 17 ДУГААР ЗҮЙЛ

### ДАРХАН ЭРХЭЭС ТАТГАЛЗАХ

1. Томьлогч улс консулын газрын гишүүнд энэ Конвенцийн 14, 15, 16 дугаар зүйлд заасан аливаа эрх ямба, дархан эрх элүүлэхээс татгалзаж болно. Энэ зүйлийн 2-т зааснаас бусад тохиолдолд ийнхүү татгалзаж байгаагаа ямагт бичгээр илэрхийлнэ.

2. Энэ Конвенцийн дагуу хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх дархан эрх эдлэх хүн иргэний болон захиргааны хэрэг үүсгэхэд үндсэн нөхөмжлэлтэй нь шууд холбоотой сөрөг нөхөмжлэлийн хувьд хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх дархан эрхээс иш татах эрхээ алдана.

3. Иргэний болон захиргааны хэргийн талаар хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх дархан эрхээс татгалзах нь шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс чөлөөлөгдөх дархан эрхээс татгалзаж байгаа хэрэг бмш бөгөөд үүний тулд жич татгалзах шаардлагатай.

ЦАХИМ АШИГТГАЛГА

ГАДААД ХАМГААГАХ  
ДААНЫ ТӨВ АРХИВ

18 ДУГААР ЗҮЙЛ  
ЧӨЛӨӨТЭЙ ЗОРЧИХ

Улсын аюулгүй байдлыг хангах зорилгоор нэвтрэхийг хориглосон  
буу хязгаарласан бүсээс бусад районд консулын газрын гишүүд, тэд-  
ний гэр бүлийн гишүүд хүлээн авагч улсын нутаг дэвсгэрээр чөлөөтэй  
зорчиж болно.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ХҮБЬ

ГАЛМУД ХАРИЛЦАДНЫ ТӨВ АРХИВ

19 ДҮГЭЭР ЗҮЙЛ

ЭРХ ЯМБА, ДАРХАН ЭРХ ЭЛЛЭХ БУУУ ЭДЛЭХГҮЙ  
ХҮМҮҮС

1. Хүлээн авагч улсын иргэн буюу байнга оршин суугч консулын газрын гишүүд энэ Конвенцид заасан эрх ямба, дархан эрхийг гагцхүү хүлээн авагч улсаас тогтоосон хэмжээнд, энэ Конвенцийн 16 дугаар зүйлийн 2-т заасныг хөндөхгүйгээр эдэлнэ. Хүлээн авагч улс консулын газраас үүргээ гүйцэтгэхэд нь саад болохгүйгээр тэдэнд хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

2. Консулын газрын гишүүний гэр бүлийн гишүүд хүлээн авагч улсын иргэн буюу байнга оршин суугч бол энэ Конвенцид заасан эрх ямба, дархан эрхийг гагцхүү хүлээн авагч улсаас тэдэнд олгосон хэмжээнд эдэлнэ.

ЦАХИМ АШИГЛАГЧ ДЭМЖЭГЧ  
ГАДААД ХАРААГЧИЙН ЦАДАННЫ ТӨВ АРХИВ

20 ЛУГААР ЗҮЙЛ

ЭРХ ЯМБА, ДАРХАН ЭРХ ЭХЛЭХ, ДУУСАХ

1. Консулын газрын гишүүн томилогдсон газартаа очихоор хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт орсон үеэс, эсвэл түүний нутаг дэвсгэрт байгаа бол консулын газарт үүргээ гүйцэтгэж эхэлсэн үеэс эхлэн энэ Конвенцид заасан эрх ямба, дархан эрх эдэлнэ.

2. Консулын газрын гишүүний гэр бүлийн гишүүд энэ зүйлийн I-д заасан үеэс, эсвэл тэд хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт орсон үеэс, эсвэл хожим нь түүний гэр бүлийн гишүүн болсон үеэс эхлэн энэ Конвенцид заасан эрх ямба, дархан эрх эдэлнэ.

3. Консулын газрын гишүүний үүрэг дуусахад өөрийн нь болон түүний гэр бүлийн гишүүний эрх ямба, дархан эрх нь уг хүн хүлээн авагч улсын нутаг дэвсгэрээс гарсан, эсвэл гарах боломжийн хугацаа өнгөрсөн хоёрын аль түрүүнд тохиолдоноор дуусна. Энэ зүйлийн 2-т заасан хүний эрх ямба, дархан эрх нь тэр консулын газрын гишүүний гэр бүлийн гишүүнд тооцогдохоо больсон үеэс дуусах боловч тэр боломжийн хугацааны дотор хүлээн авагч улсаас гарах бол ийнхүү гарглаа эрх ямба, дархан эрхээ хэвээр эдэлнэ.

4. Консулын газрын гишүүн албан үүргээ гүйцэтгэх үедээ үйлдсэн хэргийн хувьд хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх дархан эрх нь хугацаагүй үргэлжилнэ.

5. Консулын газрын гишүүн нас барвал түүний гэр бүлийн гишүүд нь хүлээн авагч улсаас гарсан, эсвэл гарах боломжийн хугацаа өнгөрсөн хоёрын аль түрүүнд тохиолдох хүртэл эрх ямба, дархан эрх эдэлсэн хэвээр байна.

21 ДҮГЭЭР ЗҮЙЛ

ХҮЛЭЭН АВАГЧ УЛСЫН ХУУЛИЙГ ХҮНДЭТГЭХ

1. Энэ Конвенцийн дагуу эрх ямба, дархан эрх эдлэх хүмүүс хүлээн авагч улсын хуулийг өөрсдийн эрх ямба, дархан эрхэд хохиролгүйгээр хүндэтгэх үүрэгтэй.
2. Консулын газрын гишүүд хүлээн авагч улсын дотоод хэрэгт оролцохгүй.
3. Консулын газрын гишүүд тээврийн хэрэгсэл ашигласнаас гуравдахь этгээдэд учруулж болох хохирлоос даатгуулах тухай хүлээн авагч улсын хуулийн аливаа заалтыг биелүүлнэ.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ХҮБЭ

ГАДААД ХАРИЛЦАДАНЫ ТӨВ АРХИВ

ТАТВАР ХУРААМЫ БОЛОН ҮҮРГЭЭС ЧӨЛӨӨЛӨГДӨХ

22 ДУГААР ЗҮЙЛ

КОНСУЛЫН ГАЗАР ЭД ХӨРӨНГИЙН ТАТВАР, ХУРААМЫААС  
ЧӨЛӨӨЛӨГДӨХ

1. Томилогч улс дараах зүйлийг олж авах, ашиглах, байлгах, захиран зарцуулахдаа хүлээн авагч улсад улс, орон нутгийн бүх татвар, хураамжаас чөлөөлөгдөнө.

а/ энэ Конвенцийн 9 дүгээр зүйлд заасны дагуу олж аваад хүлээн авагч улсын хуулийн дагуу томилогч улсын өмнөөс өмчилж, түрээслэн авч буюу бусад арга замаар ашиглаж байгаа бөгөөд гагцхүү консулын зорилгод, мөн хүлээн авагч улсын иргэн буюу байнга оршин суугч бийн консулын албан тушаалтны орон сууцанд ашиглаж байгаа газар, барилга, барилгын хэсэг,

б/ гагцхүү консулын газрын зорилгод эзэмшиж буюу ашиглаж байгаа хөдлөх эд хөрөнгө,

в/ энэ зүйлийн 1-ийн "а"-д заасан эд хөрөнгийг олж авах, захиран зарцуулахтай холбогдсон хэлцэл, бичиг баримт.

2. Энэ зүйлийн 1-ийн заалт дараах зүйлд хамаарахгүй:

а/ тодорхой төрлийн үйлчилгээний төлбөр,

б/ томилогч улс, эсвэл түүнийг төлөөлсөн хүнтэй хэлцэл байгуулсан хүнээс хүлээн авагч улсын хуулийн дагуу авах татвар, хураамж.

23 ДУГААР ЗҮЙЛ

КОНСУЛЫН ГАЗРЫН ГИШҮҮД ТАТВАР, ХУРААМЖААС  
ЧӨЛӨӨЛӨГДӨХ

1. Хүлээн авагч улсын иргэн баш буюу байнга оршин суугч бин консулын албан тушаалтан, консулын ажилтан, тэдний гэр бүлийн гишүүд нь эзэмшиж байгаа хөдлөх эд хөрөнгөд ногдох татварыг оролцуулан хүлээн авагч улсад уло, орон нутгийн бүх татвар, хураамжаас чөлөөлөгдөнө.

2. Энэ зүйлийн I-ийн заалт дор дурдсан татвар, хураамжид хамаарахгүй:

- а/ барааны үнэ буюу үйлчилгээний хөлсөнд ордог шууд бус татвар,
- б/ энэ Конвенцийн 22 дугаар зүйлд заасны дагуу чөлөөлөгдөхөөс бусад хүлээн авагч улсад байгаа амины үл хөдлөх эд хөрөнгөд ногдуулах татвар, хураамж,
- в/ өв залгамжлалд, эд хөрөнгийг шилжүүлэхэд, мөн ийнхүү шилжүүлэхэд хамаарах бичиг баримтад хүлээн авагч улсаас ногдуулах татвар,
- г/ хүлээн авагч улсад эх сурвалж нь байгаа хувийн орлогоос авах татвар, хураамж,
- д/ энэ Конвенцийн 22 дугаар зүйлд заасны дагуу чөлөөлөгдөхөөс бусад шүүх, барьцаат эзэл, захиргааны журмаар авах хураамж,
- е/ тодорхой төрлийн үйлчилгээний хөлс.

3. Хүлээн авагч улсад ашиг орлогын татвараас цалин хөлс нь чөлөөлөгдөхгүй хэнийг хөлслөн ажялуулж байгаа консулын албан тушаалтан, консулын ажилтан ашиг орлогын татварын хувьд хүлээн авагч улсын хуулийн дагуу хөлслөн авагчдад хүлээлгэх үүргийг биелүүлнэ.

24 ДҮГЭЭР ЗҮЙЛ

ЦАЛИН ХӨЛС ТАТВАР, ХУРААМЖААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ

Хүлээн авагч улсын иргэн буюу байнга оршин суугч бийн консулын газрын үйлчилгээний бүрэлдхүүний гишүүн албан үүргээ гүйцэтгэх авах цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж болон бусад орлогын хувьд хүлээн авагч улсад татвар, хураамжаас чөлөөлөгдөнө.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ХҮНД

ГАДААД ХАРИЛЦАДНЫ ТӨВ АРХИВ

## 25 ДУГААР ЗҮЙЛ

### ГААЛИЙН ТАТВАР, ҮЗЛЭГЭЭС ЧӨЛӨӨЛӨГДӨХ

1. Тээврийн хэрэгсэл зэрэг консулын газрын албан хэрэгцээнд зориулан хүлээн авагч улсын хуулийн дагуу оруулж байгаа бүх эд кмс хүлээн авагч улсад гаалийн бүх татвар, хураамжаас чөлөөлөгдөнө.

2. Консулын албан тушаалтан болон хүлээн авагч улсын иргэн биш буюу байнга оршин суугч биш түүний гэр бүлийн гишүүдийн төвхнөн суурьшихад шаардагдах эд кмс зэрэг хувийн хэрэгцээнлээ зориулан оруулж байгаа бүх эд кмс гаалийн бүх татвар, хураамжаас чөлөөлөгдөнө. Хүлээн авагч улсын иргэн биш буюу байнга оршин суугч биш консулын ажилтан энэ зүйлц заасан эрх ямба, хөнгөлөлтийг анх төвхнөн суурьших үедээ авчирсан эд кмсын хувьд эдэлнэ.

3. Энэ зүйлийн 1,2-т заасны дагуу чөлөөлөгдөх нь тээвэрлэх, хадгалах болон ажил төстэй бусад үйлчилгээний хураамжил хамаарахгүй.

4. Хувийн хэрэгцээнд зориулсан эд кмс нь холбогдох хүний шууд хэрэгцээнд шаардагдах хэмжээнээс хэтрэхгүй байна.

5. Консулын албан тушаалтан, хүлээн авагч улсын иргэн биш буюу байнга оршин суугч биш түүний гэр бүлийн гишүүдийн хувийн ачаа гаалийн үалэгээс чөлөөлөгдөнө. Гэвч ачаанд нь энэ зүйлийн 2-т дурдсанаас еер эд кмс, мөн хүлээн авагч улсын хуулиар оруулахыг хориглоосон буюу хорио цээрийн хуулиар зохицуулах эд кмс байна гэх баттай үндэслэл байвал түүнийг үзэж болно. Тэхдээ холбогдох консулын албан тушаалтанг, эсвэл түүний гэр бүлийн гишүүнийг, эсвэл консулын албан тушаалтанг төлөөлөхөөр консулын албан тушаалтан буюу түүний гэр бүлийн гишүүний заасан хүнийг байлцуулан үзнэ.

26 ДУГААР ЗҮЙЛ

НАС БАРСАН ТОХИОЛДОЛД ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ  
ТАТВАР, ХУРААМЖААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ

Хэрэв хүлээн авагч улсын иргэн биш буюу байнга оршин суугч биш консулын газрын гишүүн, эсвэл түүний гэр бүлийн гишүүн хүлээн авагч улсад нас барахад хүлээн авагч улсад үлдсэн түүний хөдлөх эд хөрөнгө нь нас барагч консулын газрын гишүүн, эсвэл консулын газрын гишүүний гэр бүлийн гишүүн байсантай нь шууд холбоотой бол хүлээн авагч улс уг эд хөрөнгөд өв хөрөнгийн болон өв залгамжлалын зэрэг бусад татвар, хураамж ногдуулахгүй. Нас барах үед нь гаргахыг хориглосноос бусад хөдлөх эд хөрөнгийг нь гаргаж болно.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ТӨВ АРХИВ

ГАДААД УЛСЫН ДИПЛОМАТИАНЫ ТӨВ АРХИВ

IY ХЭСЭГ

YYPГЭЭС ЧӨЛӨӨЛӨГДӨХ

27 ДУГААР ЗҮЙЛ

ЦЭРГИЙН АЛБАН БОЛОН БУСАД YYPГЭЭС  
ЧӨЛӨӨЛӨГДӨХ

1. Консулын газрын гишүүд, тэдний гэр бүлийн гишүүдийг хүлээн авагч улсад цэргийн шинж чанартай албан үүрэг, албадлагын аливаа алба, мөн тэдгээрт хандив оруулахвас чөлөөлнө.
2. Консулын газрын гишүүд, тэдний гэр бүлийн гишүүд хүлээн авагч улсад оршин суух зөвшөөрөл авах, томилогч улсын төлөө үүрэг гүйцэтгэхдөө хүлээн авагч улсын хуулинд заасан ажилд орох зөвшөөрөл авахтай холбогдсон аливаа үүргээс чөлөөлөгдөнө.
3. Энэ зүйлийн 2-ын заалт томилогч улсын байнгын албан хэргч биш, эсвэл орлого олохоор хүлээн авагч улсад хувийн үйл ажиллагаа эрхэлж байгаа консулын ажилтан, түүний гэр бүлийн гишүүдэд хамаарахгүй.
4. Хүлээн авагч улсын иргэн буюу байнга оршин суугч хөрөв хүлээн авагч улсын хуульд өөрөөр заагаагүй бол энэ зүйлд заасан алба, үүргийг гүйцэтгэнэ.

ЦАХИМ АЛБИЙН ГЭР БҮЛЭЙН ГИШҮҮД

ГАДААД ХАРМИЛТАНДАНС ТӨВ АРХИВ

Ү ХЭСЭГ

КОНСУЛЫН ҮҮРЭГ

28 ДУГААР ЗҮЙЛ

КОНСУЛЫН ЕРӨНХИЙ ҮҮРЭГ

1. Консулын албан тушаалтан дараах зорилгоор консулын үүрэг гүйцэтгэнэ:

а/ томилогч улс, түүний иргэдийн эрх, ашиг сонирхлыг хүлээн авагч улсад хамгаалах,

б/ томилогч улс, хүлээн авагч улсын хоорондын найрсаг харилцааг бататгахын тулд хоёр улсын эдийн засаг, худалдаа, соёл, шинжлэх ухааны харилцаа, жуулчлалыг өргөтгөхөд тус дөхөм үзүүлэх.

2. Консулын албан тушаалтан хүлээн авагч улсын улс төр, эдийн засаг, худалдаа, соёл, шинжлэх ухааны хөгжим, байцлыг хууль ёсны бүх арга замаар судалж томилогч улсын засгийн газарт мэдээлнэ.

3. Консулын албан тушаалтан хүлээн авагч улсын хуулиар хориглоогүй буюу хүлээн авагч улс татгалзахгүй бол томилогч улсаас даалгасан консулын бусад үүрэг гүйцэтгэж болно.

ЦАХИМ АНГЕМЭГЭЙН ХУВЬ

ГАДААД ХАРИУЛЦАГНАС ТӨВ АРХИВ

29 ДҮГЭЭР ЗҮЙЛ

КОНСУЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ

1. Консулын албан тушаалтан консулын үүргээ зөвхөн консулын тойргийн дотор гүйцэтгэнэ.
2. Консулын албан тушаалтан гагцхүү хүлээн авагч улсын зөвшөөрснөөр консулын тойргийн гадна консулын үүрэг гүйцэтгэх болно.
3. Консулын албан тушаалтан консулын үүрэг гүйцэтгэхдээ:
  - а/ консулын тойргийн орон нутгийн эрх бүхий байгууллагатай харилцаж болно,
  - б/ хүлээн авагч улсын хуулиар зөвшөөрдөг бол хүлээн авагч улсын төвийн эрх бүхий байгууллагатай хүлээн авагч улсын Гадаад явдлын яам буюу Төрийн департаменттаар дамжуулан харилцаж болно.
4. Консулын газар хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт консулын үйл ажиллагаа явуулж томилогч улсын хуулийн дагуу консулын хураамж авч болно. Хураамжаар авсан мөнгө нь хүлээн авагч улсад бүх татвар, хураамжаас чөлөөлөгдөнө.

ЦАХИМ АШИГДАГТЫН ХУВЬ

ГАДААД ХАРИУДАЛДЫ ТӨВ АРХИВ

ЗО ДУГААР ЗҮЙЛ

НОТАРИАТЫН ҮҮРЭГ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН  
АЧ ХОЛБОГДОЛ

1. Консулын албан тусгаалтан нотариатын дараах үүргийг томилогч улсын хуулийн дагуу гүйцэтгэж болно:

а/ хүлээн авагч улсын гадна хэрэглэхэд зориулж томилогч улсын иргэний хүсэлтээр, мөн томилогч улсад хэрэглэхэд зориулж аливаа хүний хүсэлтээр хуулийн болон бусад бичиг баримт үйлдэх, батлан гэрчлэх, гэрч уг бичиг баримт хүлээн авагч улсын хуульд харшлах ёсгүй,

б/ томилогч улс болон хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага, албан тусгаалтнаас олгосон аливаа бичиг баримтыг орчуулах, орчуулгын үнэн зөвийг гэрчлэх,

в/ томилогч улсын шүүхэд шүүхийн болон захиргааны хэрэг шийдвэрлэхэд зориулан аливаа хүнээс сайн дурын үндсэн дээр тангараг өргөж өгсөн мэдүүлгийг авах,

г/ томилогч улсын хуульд заасан бөгөөд хүлээн авагч улсын хуульд харшлахгүй нотариатын бусад бүх үүрэг гүйцэтгэх.

2. Энэ зүйлийн 1-д заасны дагуу консулын албан тусгаалтны үйлдсэн, батлан гэрчилсэн, орчуулсан хуулийн болон бусад бичиг баримт хүлээн авагч улсын хуульд харшлахгүй бол хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагын үйлдсэн, батлан гэрчилсэн, орчуулсны нэгэн адил хүлээн авагч улсад эрх зүйн ач холбогдолтой, нотлох хүчинтэй байна.

31 ДҮГЭЭР ЗҮЙЛ

ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛ, ИРГЭНИЙ БАЛЛАЛ, ХҮМҮҮС  
ЗОРЧИХТОЙ ХОЛБОГДСОН ҮҮРЭГ

Консулын албан тушаалтан дараах үүрэг гүйцэтгэж болно:

- а/ томилогч улсын иргэдийн тоо бүртгэлийг хөтлөх,
- б/ томилогч улсын иргэдийн иргэний харьяаллын талаарх аяваа өргөдлийг хүлээн авах, холбогдох бичиг баримт олгох,
- в/ томилогч улсын иргэдэд зам явах бичиг баримт олгох, хугацааг нь сунгах, хүчингүй болгох,
- г/ томилогч улсын иргэд төрсөн, нас барсныг бүртгэх,
- д/ томилогч улсад зорчих болон дамжин өнгөрөхийг хүсэгчдэд виз олгох, хэрэв эрхтэй бол сунгах.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ҮНДЭВ  
ГАДААД ХАРИЛЦАДАНЫ ТӨВ АРХИВ

32 ДУГААР ЗҮЙЛ

ШҮҮХИЙН БОЛОН БУСАД БИЧИГ БАРИМТ  
ДАМЖУУЛАХ

Консулын албан тушаалтан томилогч улс, хүлээн авагч улсын хоорондын хүчин төгөлдөр олон улсын гэрээний дагуу, хэрэв ийм гэрээгүй бол хүлээн авагч улсын хуулийн дагуу томилогч улсын иргэд болон байнга оршин суугчдад шүүхийн болон бусад бичиг баримт дамжуулах эрхтэй.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ХҮЭВ

ГАРГАМД ХАРИЛЦАДАНЫ ТӨВ АРХИВ

39 ДУГААР ЗҮЙЛ

ТОМЬЛОГЧ УЛСЫН ИРГЭДИЙН АШИГ СОНИРХЛЫГ  
ТӨЛӨӨЛӨХ

1. Хэрэв томьлогч улсын иргэн эзгүй буюу бусад хүндэтгэх шалтгаанаар эрх, ашиг сонирхлоо тухайн үед хамгаалж чадахгүй бол консулын албан тушаалтан уг иргэнийг хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагын өмнө хүлээн авагч улсын хуулийн дагуу консулын тойрогт төлөөлөх эрхтэй. Ийнхүү төлөөлөх нь уг иргэн төлөөлөгчөө сонгох буюу эрх, ашиг сонирхлоо өөрөө хамгаалах хүртэл үргэлжилнэ.

2. Консулын албан тушаалтан консулын тойрогтоо томьлогч улсын иргэнтэй харилцах, түүнд зөвлөлгөө өгөх, бүх талын дэмжлэг үзүүлэх, хэрэв шаардлагатай бол эрх зүйн туслалцаа үзүүлэх арга хэмжээ авах эрхтэй.

3. Энэ зүйлийн заалт нь эмгөөлөгчийн үүрэг гүйцэтгэх эрхийг консулын албан тушаалтанд олгохгүй.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН 39

ГАДААД ХАРИУЦЛАГЧ АНГЫН ТӨВ АРХИВ

### 34 ДҮГЭЭР ЗҮЙЛ

#### ТОМИЛОГЧ УЛСЫН ИРГЭН НАС БАРСАН ТУХАЙ МЭДЭГДЭХ

1. Хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага томилогч улсын иргэн хүлээн авагч улсад нас барсныг мэдвэл консулын зохих албан тушаалтайд даруй мэдэгдэж, түүний хүсэлтээр нас барсны гэрчилгээ буюу нас барсныг нотлох бусад бичиг баримтын хуулбарыг томилогч улсын консулын газарт өгнө.

2. Консулын албан тушаалтан томилогч улсын нас барсан иргэний өв хөрөнгө, өв залгамжлагч, хувь авагчийн тухай мэдээ болон гэрээслэл глдээсэн бол түүний хувийг консулын тойргийн орон нутгийн эрх бүхий байгууллагаас авах эрхтэй.

3. Хүлээн авагч улсад нас барсан хүний өв хөрөнгө томилогч улсын иргэнд хамаарах бол консулын албан тушаалтан энэ зүйлийн 2-г заасантай адил мэдээг консулын тойргийн орон нутгийн эрх бүхий байгууллагаас мөн авах эрхтэй.

ЦАХИМ АШМУУЛТЫН НЭВЭ  
ГАДИМД ХАРМИЛДАННЫ ТӨВ АРХИВ

35 ДУГААР ЗҮЙЛ

ӨӨ ХӨРӨНГӨТЭЙ ХОЛБОГДСОН ҮҮРЭГ

1. Консулын албан тушаалтан дараах эрх адална:

- а/ томилогч улсын нас барсан иргэний хүлээн авагч улсад үлдсэн өв хөрөнгийг хамгаалахаар зохих арга хэмжээ авах, үүнтэй холбогдуулан хүлээн авагч улсад байнга оршин суудаггүй томилогч улсын иргэний ашиг сонирхлыг уг иргэн төлөөлөгчөө сонгох хүртэл хамгаалахын тулд хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагатай хариуцах, уг өв хөрөнгийг хадгалж битүүмжлэх, хэрэг шийдвэрлэхэд байлцахаар хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагаас хүсэх,
- б/ аль нэг улсын нас барсан иргэний хүлээн авагч улсад үлдсэн эд хөрөнгийг хүлээн авах эрхтэй буюу эрхтэй гэж өөрийгөө үзэж байгаа бөгөөд хүлээн авагч улсад өөрөө байхгүй буюу төлөөлөх хүнгүй томилогч улсын иргэний ашиг сонирхлыг хүлээн авагч улсын хуулийн дагуу хамгаалах.

2. Нас барсан хүний мөнгө, бусад эд хөрөнгийг хүлээн авагч улсад байнга оршин суугч биш томилогч улсын иргэн авах эрхтэй бол томилогч улсын консулын албан тушаалтан уг мөнгө, бусад эд хөрөнгийг түүнд дамжуулан өгөхөөр хүлээн авах эрхтэй. Мөнгө, бусад эд хөрөнгө гэдэгт шүүх, байгууллага болон хүнээс өөр замаар дамжуулахаас бусад өв хөрөнгийн хувь, хөдөлмөрийн гэрээний дагуу авах төлбөр, тэтгэвэр, нийгмийн хэрэглээний фондоос авах хувь, лаатралын орлого энэхүү зүйлд мөн хамаарна. Уг шүүх, байгууллага болон хүн консулын албан тушаалтнаас дараах зүйлийг шаардах болно:

- а/ хүлээн авагч улсын гадна байгаа уг иргэнээс түүнд олгосон итгэмжлэл буюу бусад зөвшөөрлийг үзүүлэх,

- б/ мөнгө, бусад эд хөрөнгийг уг иргэн хүлээн авсан тухай боломжтой баталгаа үзүүлэх,
- в/ уг хүн ийм баталгааг үзүүлэх боломжгүй бол мөнгө, бусад эд хөрөнгийг буцааж өгөх.

3. Консулын албан тушаалтан энэ зүйлийн 1,2-т заасан үүргийг хүлээн авагч улсын хуулийн дагуу хэрэгжүүлэх бөгөөд хүлээн авагч улсын иргэдийн нэгэн адим хүлээн авагч улсын иргэний хуулийн харьцууллага хүлээнэ. Эдгээр зүйл нь өмгөөлөгчийн гүрэг гүйцэтгэх үүргийг консулын албан тушаалтанд олгохгүй.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ХУВЬ

ДАРГАД ХАРИЛЦАДНЫ ТӨВ АРХИВ

36 ДУГААР БҮЙЛ

АСРАН ХАМГААЛАХ, ХАРГАЛЗАН ДЭМЖИХТЭЙ  
ХОЛБОГДСОН ҮҮРЭГ

1. Хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага томилогч улсын насанл хүрээгүй, эсвэл эрхийн чадваргүй иргэнд асран хамгаалагч буру харгалзан дэмжигч томилох, мөн томилогч улсын иргэн хүлээн авагч улсад байгаа эд хөрөнгөө ямар нэг шалтгаанаар зохицуулж чадахгүй бол уг эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авах шаардлагатайг консулын газарт бичгээр мэдэгдэнэ.

2. Консулын албан тушаалтан томилогч улсын иргэний асран хамгаалах буру харгалзан дэмжих, мөн уг иргэний хамгаалалтгүй үлдсэн эд хөрөнгийг харгалзвал зохих хүний нэрийг хүлээн авагч улсын шүүх, эрх бүхий бусад байгууллагад хүлээн авагч улсын хуулийн дагуу дөвшүүлж болно.

ЦАХИМ АШИГЛАГЧ

ГАДААД ХАРИУДААНЫ ТӨВ АРХИВ

37 ДУГААР ЗҮЙЛ

ТОМИЛОГЧ УЛСЫН ИРГЭНТЭЙ ХАРИЦАХ

1. Томилогч улсын иргэний хувийн эрх чөлөөг ямар нэг хэлбэрээр хязгаарласан бол хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага томилогч улсын консулын газарт тухай бүр 72 цагийн дотор аль болох түргэн мэдэгдэнэ. Уг иргэний хувийн эрх чөлөөг хязгаарласан шалтгааныг консулын албан тушаалтанд түүний хүсэлтээр мөн саадгүй мэдэгдэнэ.

2. Хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага энэ зүйлийн дагуу консулын албан тушаалтантай харилцах эрхтэйг томилогч улсын иргэнд даруй мэдэгдэнэ.

3. Консулын албан тушаалтан хувийн эрх чөлөөг нь хязгаарласан томилогч улсын иргэнтэй захиллаар болон бусад хэлбэрээр харилцах, түүнд эрх зүйн туслалцаа үзүүлэх, түүнийг төлөөлөх талаар зохих арга хэмжээ авах эрхтэй.

4. Консулын албан тушаалтан хувийн эрх чөлөөг нь ямар нэг хэлбэрээр хязгаарласан томилогч улсын иргэнтэй очиж уулзах, томилогч улсын буюу хүлээн авагч улсын хэлээр ярилцаж харилцах, түүнийг хуулийн талаар төлөөлөх эрхтэй. Уулзалтыг аль болох түргэн зохиох бөгөөд уулзах зөвшөөрлийг аль ч тохиолдолд томилогч улсын консулын газарт мэдэгдсэнээс хойш 24 цагийн дотор олгоно. Дараагийн уулзалтыг түрүүчийн уулзалтаас хойш нэг сараас хэтрэхгүй хугацаанд консулын албан тушаалтаны хүсэлтээр зохиож байна.

5. Томилогч улсын иргэнд холбогдох хэргийн байцаан шийтгэх ажиллагааг хүлээн авагч улсад явуулах бол холбогдох байгууллага уг хэргийн талаар консулын албан тушаалтанд хүсэлтийн нь дагуу мэдэгдэж, байцаан шийтгэх болон давж заалдах ажиллагааныг аль ч шатанд байлцахыг консулын албан тушаалтанд зөвшөөрнө.

6. Энэ зүйлийн заалтад хамаарах иргэн түүнийг албадан саатуулсан байгууллагын холбогдох журмын дагуу хоол хүнс, хувцас, эм, унших зүйлийг консулын албан тушаалтнаас илгээмжээр авч болно.

7. Энэ зүйлд заасан эрх хүлээн авагч улсын хуулийн дагуу хэрэгжих боловч уг хууль энэ эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэх ёстой.

8. Томилогч улсын иргэдэд хамаарах энэ зүйлийн заалтууд нь хүлээн авагч улсаас хүчэн төгөлдөр орох виз буюу хүлээн авагч улсад орох эрх олгосон өөр зохих бичиг баримт авч, томилогч улсын хүчин төгөлдөр паспортаар буюу зөв явах хууль ёсны өөр бичиг баримтаар хүлээн авагч улсад түр байхаар орсон бөгөөд хүлээн авагч улсын иргэн гэж хүлээн авагч улс үзэж байгаа хүмүүст мөн хамаарна. Хүлээн авагч улсад байх зөвшөөрлийн хугацаа нь дууссан боловч шүүхийн болон захиргааны байгууллагын шийдвэр гараагүйгээс сайн дураараа гарч явах боломжгүй байгаа хүмүүст энэ заалт мөн адил хамаарна. Мөн өөрөөс нь үл хамарах шалтгаанаар хүлээн авагч улсад сагтсан гадаадын хүмүүсээс шаарддаг бичиг баримтаас өөр бичиг баримтыг хүлээн авагч улсаас авалгүйгээр хүлээн авагч улсаас гарч явахыг уг хүмүүст зөвшөөрнө.

9. Хүлээн авагч улс томилогч улсын иргэн томилогч улсын консулын газартайгаа харилцах, түүнд ороход нь ямар нэг хэлбэрээр саад учруулж болохгүй.

10. Томилогч улсын консулын албан тушаалтан томилогч улсын иргэнийг эрэн сурвалжлахад тусламцаа үзүүлэхийг хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагаас хүсч болно. Хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага боломжийн бүх арга хэмжээг авч, холбогдох боломжийн бүх мэдээг өгнө.

ЭВ ДУГААР ЗҮЙЛ

ТОМИЛОГЧ УЛСЫН ХӨЛӨГ ОНГОЦТОЙ  
ХОЛБОГДСОН ҮҮРЭГ

1. Консулын албан тушаалтан хүлээн авагч улсын боомт буюу нутгийн болон дотоодны усанд байгаа томилогч улсын хөлөг онгоц, түүний баг, зорчигчдод аливаа тусламж, дэмжлэг үзүүлэх эрхтэй. Хөлөг онгоц эрэгтэй харилцахыг зөвшөөрмөгц консулын албан тушаалтан түүн дээр очиж болно. Хөлөг онгоцны багийн гишүүд консулын албан тушаалтантай саадгүй харилцаж болно.

2. Консулын албан тушаалтан томилогч улсын хөлөг онгоцны талаар дараах үүрэг гүйцэтгэж болно:

а/ хөлөг онгоцонд болсон хэрэг явдлыг хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагын эрхэд хохирол учруулахгүйгээр мөрдөн шалгах, багийн гишүүдээс асуух, хөлөг онгоцны бичиг баримтыг шалгах,

б/ хөлөг онгоцны аялал, очих газрын тухай мэдээлэл авах, хөлөг онгоц боомтод орох, байх, гарахад туслах,

в/ хөлөг онгоцны ахмад, багийн гишүүний хоорондын маргааныг хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагын эрхэд хохирол учруулахгүйгээр томилогч улсын хуулийн дагуу шийдвэрлэх,

г/ хөлөг онгоцны багийн гишүүн, зорчигчийг эмчлүүлэх болон буцаах арга хэмжээ авах,

д/ хөлөг онгоцны талаар томилогч улсын хуульд дурдсан мэдэгдэл, бусад бичиг баримтыг хүлээн авах, үйлдэх, гэрчлэх.

3. Хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага томилогч улсын хөлөг онгоц, эсвэл түүний ахмад буюу багийн гишүүний талаар

албадлага, мөрдлөгийн арга хэмжээ авах бол консулын албан тушаалтанд урьдчилан мэдэгдэнэ. Хэрэв хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага урьдчилан мэдэгдэж амжаагүй буюу консулын албан тушаалтан байршаагүй бол тэд болсон хэргийн тухай болон авсан арга хэмжээнийхээ тухай консулын албан тушаалтанд аль болох даруй мэдэгдэнэ.

4. Энэ зүйлийн 3-ын заалт нь боомтын районы эрх бүхий байгууллага багийн гишүүнийг эх газар дээр байцаах бүх тохиволлолд мөн адил хамаарна.

5. Энэ зүйлийн 3-ын заалт хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагаас хийх гяаль, хилээр шалган нэвтрүүлэх болон эрүү мэндийн ердийн үзлэг, түүнчлэн хөлөг онгоцны ахмадын хүсэлтээр буюу зөвшөөрлөөр хийх аливаа үйлдэлд хамаарахгүй.

6. Томилогч улсын хөлөг онгоц хүлээн авагч улсад осолдвол, мөн бусад улсын осолдсон хөлөг онгоцны ичааны хэсэг болох томилогч улсын болон түүний иргэний эд хөрөнгө хүлээн авагч улсын эрэг, дотоодын болон нутгийн уснаас олдвол буюу боомтод хүргэгдвал хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага консулын албан тушаалтанд аль болох даруй мэдэгдэнэ. Мөн тэд хөлөг онгоц, түүний зорчигчид, багийн гишүүд, ачаа, эд хөрөнгө, эд ангийг аварч хамгаалах талаар авсан арга хэмжээнийхээ тухай консулын албан тушаалтанд мэдэгдэнэ.

7. Консулын албан тушаалтан томилогч улсын осолдсон хөлөг онгоц, түүний багийн гишүүд, зорчигчлод аливаа туслалцаа үзүүлж болно. Энэ зорилгоор консулын албан тушаалтан даргах арга хэмжээ авч болно:

а/ уг хөлөг онгоцыг зэсүүлэх;

б/ хөлөг онгоцны ахмал, харьяалагдах байгууллага, даат-

галын газар болон түүний ашиг сонирхлыг төлөөлөх эрхтэй бусад хүн уг хөлөг онгоц, түүний ачааны талаар шаардлагатай арга хэмжээ авч чадахгүйд хүрвэл консулын албан тушаалтан тэдний өмнөөс тийм арга хэмжээ авах.

8. Консулын албан тушаалтан хүмүүс, ачааг аварч хамгаалах, хөлөг онгоцонд засвар хийлгэх талаар хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагаас туслалцаа хүсч болно.

9. Томилгогч улсын осолдсон хөлөг онгоц, түүний ачаа, нөөцийг хүлээн авагч улсад ашиглахгүй бол гаалийн татвараас чөлөөлнө.

10. Консулын албан тушаалтан томилогч улсын хөлөг онгоцны талаар үүрэг гүйцэтгэхтэй холбогдоон аливаа асуудлаар хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагаас туслалцаа хүсч болно.

ЦАХИМ АШИГЛАГЧИЙН ҮЗВЭР  
УДААД ХАВЧИЛЦАДНЫ ТӨВ АРХИВ

39 ДҮГЭЭР ЗҮЙЛ

ТОМИЛОГЧ УЛСЫН АГААРЫН ХӨЛӨГТЭЙ  
ХОЛБОГДСОН ҮҮРЭГ

Энэ Конвенцийн 38 дугаар зүйлийн холбогдох заалт томилогч улс болон хүлээн авагч улсын хоорондын олон улсын хүчин төгөлдөр гэрээний заалтад харшлахгүй бол томилогч улсын агаарын хөлөгт нэгэн адил хамаарна.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ХҮВ

ГАЗРАД ХАРИЛЦАДАНЫ ТӨВ АРХИВ

ҮИ ХЭСЭГ

БУСАД ЗААЛТ

40 ДҮГЭЭР ЗҮЙЛ

ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР КОНСУЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ

1. Томилогч улсаас хүлээн авагч улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар консулын үүрэг гүйцэтгэж болно. Консулын үүрэгт хамаарах энэ Конвенцийн заалтууд нь дипломат төлөөлөгчийн газар консулын үүрэг гүйцэтгэхэд мөн хамаарна.

2. Дипломат төлөөлөгчийн газар консулын үүрэг гүйцэтгэх дипломат бүрэлдэхүүний гишүүдийн овог нэр, аэрэг, албан тушаалыг хүлээн авагч улсын Гадаад явдлын яаманд буюу Төрийн департаментад мэдэгдэнэ.

3. Консулын үүрэг гүйцэтгэх дипломат бүрэлдэхүүний гишүүд энэ Конвенцийн 35 дугаар зүйлийн 3-т зааснаас бусад тохиволдол дипломат эрх ямба, дархан эрхээ хэвээр эдэлнэ.

ЦАХИМ АШГИЛАЛТЫН ХУВЬ

ГАДААД ХАРААГЧИЙН ГАЗАР КОНСУЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ТӨВ АРХИВ

• 41 ДҮГЭЭР ЗҮЙЛ

ГУРАВДАХЬ УЛСЫН ӨМНӨӨС КОНСУЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ

Консулын албан тушаалтан хүлээн авагч улсад мэдэгдэхэд хүлээн  
авагч улс татгалзахгүй бол гуравдахь улсын өмнөөс хүлээн авагч ул-  
сад консулын үүрэг гүйцэтгэж болно.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ХҮЭВ

ГАДААД ХАРИЛЦАДНЫ ТӨВ АРХИВ

42 ДУГААР ЗҮЙЛ

КОНСУЛЫН ҮҮРЭГ ТҮР ГҮЙЦЭТГЭХ

Хүлээн авагч улсад мэдэглэхэд хүлээн авагч улс татгалзахгүй бол томьлогч улсаас гуравдахь улсад суугаа консулын албан тушаалтан хүлээн авагч улсад консулын үүрэг түр гүйцэтгэж болно. Тэхдээ хүлээн авагч улсад 30-аас цөөн хоногоор томьлогдсон консулын албан тушаалтан хүлээн авагч улсад эрх ямба, дархан эрх эдлэхгүй.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ХҮБЭ

ГАДРАНД ХАРИЛЦАДНЫ ТӨВ АРХИВ

43 ДУГААР ЗҮЙЛ

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, ХУРАЛД ТОМИЛОГЧ  
УЛСЫГ ТӨЛӨӨЛӨХ

Консулын албан тушаалтан хүлээн авагч улсад мөлэгдэхэд хүлээн авагч улс татгалзахгүй бол олон улсын байгууллагад болон олон улсын хуралд томилогч улсаа төлөөлж болно. Тэр ийнхүү төлөөлөхдөө олон улсын байгууллага болон хуралд хамаарах эрх ямба, дархан эрх эдэлвэ. Консулын албан тушаалтан консулын үүрэг гүйцэтгэхдээ консулын албан тушаалтанд энэ Конвенцийн дагуу олгосноос илүү хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх дархан эрх эдлэхгүй.

ЦАХИМ АШИГЛАЛТЫН ГЭВЭЛ  
ГАДААД ХАРИЛЦАДНЫ ТӨВ АРХИВ

III ХЭСЭГ  
ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

44 ДҮГЭЭР ЗҮЙЛ

ХҮЧИН ТӨГӨӨДӨР БОЛОХ, ЦУЦЛАХ

1. Энэ Конвенц нь хоёр улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн дагуу соёрхон батлагдах бөгөөд батламж жуух бичгүүдийг солилцсоноос хойш 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэ Конвенц Хэлэлцэн тохирогч хоёр Талын нутаг дэвсгэрт үйлчилнэ. Энэ Конвенцийг хэрэгжүүлэх, тайлбарлахтай холбогдсон аливаа маргааныг дипломат шугамаар шийдвэрлэнэ.

3. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь энэ Конвенцийг хэдий ч цуцалж болох бөгөөд ийнхүү цуцлах тухайгаа мэдэгдсэнийг Хэлэлцэн тохирогч нөгөө Тал нь хүлээн авснаас хойш 6 сарын дараа Конвенц хүчингүй болно.

ЦАХИМ АШИГЛЭГДЭНХЭВЬ

ГАДААД ХАРИУЛГААНЫ ТӨВ АРХИВ


ҮҮНИЙГ НОГОЛЖ, өөрсдийн засгийн газраас зохих хэлбэрээр бүрэн эрх олгогдсон дараах хүмүүс энэхүү конвенцид гарын үсэг зурав.

1990 оны 8 дугаар сарын 2-нд Улаанбаатар хотноо монгол, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх хувь тус бүр адил хүчтэй байна.

БҮГД НАЙРАМЛАХ МОНГОЛ АРД  
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨӨС



АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨӨС



ЦАХИМ АШИГЛАЛТЫН ХУВЬ  
ТАГААД ХАШИГЛАЛТЫН ХУВЬ  
ГИЛЦАДНЫ ТӨВ АРХИВ